

Аудитын тайлан

Хавсралт1: Аудитын гэрчилгээ
Хавсралт2: Аудитын тайлан
Хавсралт1: Менежментийн захидал
Хавсралт1: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Код: УАГ-САГ/2018/118/ СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 260512 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Улаанбаатар хот
2018 он



Агуулга

| | | |
|------|--|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 0 |
| 2 | Аудитын тайлан | 1 |
| 2.1 | Оршил..... | 1 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... | 1 |
| 2.3 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 2 |
| 2.4 | Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 3 |
| 2.5 | байгууллагын дотоод хяналт..... | 3 |
| 2.6 | орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга..... | 3 |
| 2.7 | Шилэн дансны мэдээлэл | 4 |
| 2.8 | Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар | 4 |
| 2.9 | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл | 4 |
| 2.10 | Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл | 5 |
| 2.11 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:..... | 5 |
| 2.12 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 5 |
| 3 | Менежментийн захидал | 6 |
| 3.1 | | 7 |
| 3.2 | | 8 |
| 4 | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 9 |
| 4.1 | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..... | 9 |
| 4.2 | Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан..... | 10 |
| 4.3 | Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 11 |
| 4.4 | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан | 12 |
| 4.5 | Аудит хийгдсэн орлого, зардлын гүйцэтгэлийн тайлан | 14 |
| 4.6 | Аудит хийгдсэн улсын төсвөөс авсан хөрөнгийн гүйцэтгэл..... | 16 |

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайланг Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн захирал М.Должин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурьдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар Ас арвай аудит ХХК аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 14-нээс 2018 оны 03 дугаар сарын 01-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, хүргүүлэв.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Засгийн газрын 131 дүгээр тогтоолоор Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль болон шинэчлэн байгуулсан байна.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Журам шинэчлэн батлах тухай” заавар, Боловсролын тухай, Нийгмийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай хуулиуд зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2, Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2017 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тушаалаар тус сургуулийн бүтцийг баталж, орон тоог 63-аар тогтоосон.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Эрхэм зорилго:

- Инноваци
- Энтерпренершип
- Тогтвортой ногоон хөгжлийн концепцид суурилсан сургалт, эрдэм шинжилгээг хослуулж, хөдөлмөрийн зах зээлд тэргүүлэгч мэргэжилтэн бэлтгэх


Үнэт зүйл:

- Хөгжилд хөтөч, шинийг эрэлхийлэгч, судлаач **БАГШ**
- Ногоон, эрүүл, нээлттэй **ОРЧИН**
- Олон талт мэдлэг, ур чадвартай, зөв дадал, эерэг хандлагатай, ирээдүйн хөгжлийг тодорхойлогч энтрепренёр **ОЮУТАН**
- Тэгш, хүртээмжтэй, чанартай **БОЛОВСРОЛ**

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хүрээлэн байгаа орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахад чиглэсэн арга хэмжээ, хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлж **НОГООН ИХ СУРГУУЛЬ** болохоор зорин ажиллаж байна.

Тус сургууль нь 170011 тоот сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-өөр 247 суралцагчийг 2017-2018 оны хичээлийн жилд ХҮИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт, 29 суралцагчдын магистрын хөтөлөр, бэлтгэл магистрын хөтөлбөрт тус тус элсүүлэн суралцуулж байна.

БСШУС-ын сайдын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/165-тоот тушаалаар 256.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.



2.4 Аудитын ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 26 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Powersoft” програм хангамжаар бэлтгэсэн байна.


2.5 БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 131 тоот төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагыг өөрчлөн байгуулах тухай тогтоолоор Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг Монгол Улсын их сургуулиас тусгаарлан Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль болгон өөрчлөн зохион байгуулж, 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын үйл ажиллагааг бие даалган ажиллууж эхэлсэн ба өөрчлөн байгуулагдсан сургуулийн орон тоог батлахдаа багш, ажилчдын ажлын байрыг хэвээр хадгалж, 2017 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс 47 багш, ажилтныг 2018 онд үлдсэн багш ажилтнуудыг шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна. 2018-2019 оны хичээлийн жилээс сургуулийн бүтцэд хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтний орон тоог баталж дотоод аудитын чиг үүргийг хариуцуулан ажилуулахаар төлөвлөж байна.

2.6 ОРЛОГО, ЗАРДЛЫН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Нийт орлогын 2017 оны гүйцэтгэл 1,081.2 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 4.4 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар давж биелсэн байна.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн нийт зарлага 2017 оны гүйцэтгэлээр 657.3 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 40.1 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар хэмнэгдсэн байна. Нийт зарлагын дүнд урсгал зардал 59.0 хувь, хөрөнгийн зардал



41.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт зардлын дүнд хөрөнгийн зардлын эзлэх хувь өндөр байгаа нь 2017 онд улсын төсвийн санхүүжилтээр 256.1 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт авсантай холбоотой.

Цалин хөлсний зардал 10.7 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар, бараа үйлчилгээний нийтлэг зардал 4.6 сая төгрөгөөр буюу 10 хувиар, сургалтын үйлчилгээний зардал 2.5 сая мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар, эрдэм шинжилгээ, инновацийн зардал 0.6 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар, тогтмол зардал 11.0 сая төгрөг буюу 15.6 хувиар, хөрөнгийн зардал 10.7 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг өөрийн цахим мэдээллийн санд байршуулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, худалдан авсан ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 26 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Баянхонгор дахь салбар 2017 оны 11 дүгээр сарын 16-ний өдөр 018 дугаартай төлбөрийн даалгавраар нүүрсний үнэнд гэж 0.9 сая төгрөгийг Б.Жүгдэрийн дансанд шилжүүлсэн байна. Нүүрсний үнэ нэхэмжилсэн дүнгээс 0.2 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу байсан.
2. Жолооч О.Ганхүү нь жолоочийн тооцооны хуудсыг хөтлөлгүй, бүрэн бус баримтаар бензиний үнэд 0.1 сая төгрөг авсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг зөрчсөн байна .

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, гүйлгээ хийх зөвлөмж хүргүүлэх.

3. Монгол улсын их сургууль нь өөрийн өмчлөлд байсан “Хөвсгөл усан зам” ХХК-ийн 23606 ширхэг нийт 100.00 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй хувьцааг Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн өмчлөлд шилжүүлсэн байна. Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь өөрийн өмчлөлд шилжиж ирсэн “Хөвсгөл усан зам” ХХК-ийн 23606 ширхэг нийт 100.00 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй хувьцааг нягтлан бодох

бүртгэлд өөрийн хийсэн хөрөнгө оруулалтаар бүртгэж авсан байна. Гэвч уг хувьцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д бүртгүүлж баталгаажуулаагүй нь Компанийн тухай хуулийн 45.4-д “Компанийн үнэт цаас эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны хэмжээ /тоо/-г үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх үүрэг хүлээнэ.”, 45.5-д “Энэ хуулийн 45.4-т заасны дагуу бүртгүүлснээр уг үнэт цаасыг эзэмшигчийн эрх үүснэ.” гэж заасныг зөрчсөн байна.

4. **Шийдвэрлэсэн:** Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь өөрийн өмчлөлд шилжиж ирсэн 100.00 сая төгрөгийн хувьцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д бүртгүүлэх.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.10 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

1. Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 100.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн.

2.11 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-д заасны дагуу тодорхойлсон. Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 453.3 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.12 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд дээр дурьдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурьдсан зөвлөмжийг цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг харуулав.



3.1

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

1. Баянхонгор дахь салбар 2017 оны 11 дүгээр сарын 16-ний өдөр 018 дугаартай төлбөрийн даалгавраар нүүрсний үнэд гэж 0.9 сая төгрөгийг Б.Жүгдэрийн дансанд шилжүүлсэн байна. Нүүрсний үнэ нэхэмжилсэн дүнгээс 0.2 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу байсан.
2. Жолооч О.Ганхүү нь жолоочийн тооцооны хуудсыг хөтлөлгүй, бүрэн бус баримтаар бинзений үнэд 0.1 сая төгрөг авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлж нягтлан бодох бүртгэлд тусгана” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Зохих хууль дүрмийг мөрдөж ажиллана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.2

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

1. Монгол улсын их сургууль нь өөрийн өмчлөлд байсан “Хөвсгөл усан зам” ХХК-ийн 23606 ширхэг нийт 100.00 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй хувьцааг Худалдаа үйлдвэрийн их сургуулийн өмчлөлд шилжүүлсэн байна. Худалдаа үйлдвэрийн их сургууль нь тус хувьцааг хууль тогтоомжийн дагуу өөрийн нэр дээр шилжүүлж аваагүй байна.

Компанийн тухай хуулийн 45.4-д “Компанийн үнэт цаас эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны хэмжээ /тоо/-г үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх үүрэг хүлээнэ.”, 45.5-д “Энэ хуулийн 45.4-т заасны дагуу бүртгүүлснээр уг үнэт цаасыг эзэмшигчийн эрх үүснэ.” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Эрхийн актгүй хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь өөрийн өмчлөлд шилжиж ирсэн 100.00 сая төгрөгийн хувьцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д бүртгүүлэх.

2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Зохих хууль дүрмийн дагуу шийдвэрлэнэ.



4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА**4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхлэлтийн тайлан | Эцсийн үлдэгдэл |
|--|-------------------------|-------------------------|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 265,507,313.37 | 710,501,386.31 |
| МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | | 423,817,857.94 |
| Банкинд байгаа мөнгө-төгрөг | | 298,817,857.94 |
| Банкинд байгаа мөнгө-гадаад валют | | |
| Богино хугацаат хадгаламж | | 125,000,000.00 |
| АВЛАГА | 72,728,293.57 | 89,342,236.57 |
| Бусад авлага | 67,438,293.57 | 67,641,596.57 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 5,290,000.00 | 21,700,640.00 |
| БАРАА МАТЕРИАЛ | 192,779,019.80 | 197,341,291.80 |
| Түүхий эд материал | | |
| Тусгай зориулалттай материал | | |
| Хангамжийн материал | 192,779,019.80 | 197,341,291.80 |
| Бусад хангамжийн материал | | |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,328,691,597.51 | 3,512,691,970.53 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | |
| Биет хөрөнгө | | |
| Барилга байгууламж | 4,259,202,300.50 | 4,448,502,300.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,582,335,593.39) | (1,620,237,298.36) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 36,299,500.00 | 36,299,500.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (36,299,500.00) | (36,299,500.00) |
| Машин тоног төхөөрөмж | 564,505,351.53 | 485,531,461.68 |
| Хуримтлагдсан элэгдэл | (487,480,718.53) | (367,348,299.31) |
| Тавилга, эд хогшил | 438,224,891.31 | 454,271,242.21 |
| Хуримтлагдсан элэгдэл | (285,976,073.86) | (299,780,546.92) |
| Нийтийн тохижилтын хөрөнгө | 29,391,100.00 | 29,391,100.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (28,160,547.40) | (28,398,767.62) |
| Бусад үндсэн хөрөнгө | 22,333,040.00 | |
| Хуримтлагдсан элэгдэл | (22,333,040.00) | |
| Биет бус хөрөнгө | | |
| Номын фонд | 288,167,387.35 | 276,807,278.35 |
| Програм хангамж | | 4,200,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (3,400,000.00) |
| Бусад биет бус хөрөнгө | 33,153,500.00 | 33,153,500.00 |
| “Хөвсгөлийн усан зам” ХХК-д хувьцаагаарх хөрөнгө оруулалт | 100,000,000.00 | 100,000,000.00 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,594,198,910.88 | 4,223,193,356.84 |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 3,797,387.19 | 297,885,452.19 |
| Ажилчидтай холбоотой тооцоо | 3,797,387.19 | |
| Бараа үйлчилгээний зардлын тооцоо | | 3,797,387.19 |
| Татаас санхүүжилтын тооцоо | | 11,143,575.00 |
| Урьдчилж орсон орлого | | 282,944,490.00 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,590,401,523.69 | 3,925,307,904.65 |
| Засгийн газрын хувь оролцоо | 3,590,401,523.69 | 3,590,401,523.69 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ | | |
| Өмч: - төрийн | | 3,590,401,523.69 |
| Хуримтлагдсан үр дүн | | 334,906,380.96 |
| Тайлант үеийн үр дүн | | 334,906,380.96 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,594,198,910.88 | 4,223,193,356.84 |

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|--|---------------------|-----------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 802,441,929.68 |
| ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | | 324,044,415.00 |
| Улсын төсвөөс | | 288,586,325.00 |
| Урсгал | | 32,436,825.00 |
| Хөрөнгийн | | 256,149,500.00 |
| Орон нутгийн төсвөөс | | 19,642,090.00 |
| Бусад тусгай зориулалтын сангаас | | 15,816,000.00 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 5,000,000.00 |
| Төсөвт байгууллагаас | | |
| Бусад байгууллагаас | | 5,000,000.00 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ТӨЛБӨРТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | | 473,397,514.68 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | | 329,792,520.00 |
| Үндсэн бус ажил үйлчилгээний орлого | | 143,604,994.68 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | | 453,285,189.72 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | |
| АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ | | 241,894,419.82 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | | 217,827,353.54 |
| Үндсэн цалин | | 217,827,353.54 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 24,067,066.28 |
| НДШ-ийн зардал | | 24,067,066.28 |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | | 211,390,769.90 |
| Тогтмол зардал | | |
| Гэрэл цахилгааны зардал | | 14,921,463.15 |
| Түлш шатахууны зардал | | 11,276,840.00 |
| Цэвэр, бохир усны зардал | | 6,238,523.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| Бичиг хэргийн зардал | | 840,217.02 |
| Тээвэр шатахууны зардал | | 966,000.00 |
| Шуудан холбооны зардал | | 697,609.00 |
| Дотоод томилолтын зардал | | 1,171,430.00 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | | 11,070,373.00 |
| Сургалт семинарын зардал | | 2,000,000.00 |
| Эрдэм шинжилгээний зардал | | 18,359,850.00 |
| Аж ахуйн зардал | | 6,529,494.03 |
| Төлбөр, хураамж, татварууд | | 7,229,419.60 |
| Харуул хамгаалалтын зардал | | 27,382,200.00 |
| Банкны шимтгэлийн зардал | | 91,800.00 |
| Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардал | | 4,473,900.00 |
| Урсгал завсарын зардал | | 8,036,255.72 |
| Гадаад арга хэмжээний зардал | | 2,172,688.00 |
| Оюутны үйл ажиллагааны зардал | | 10,522,978.40 |
| Элэгдлийн зардал | | 71,013,477.98 |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | | 3,505,140.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | | 2,891,111.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | | 349,156,739.96 |
| ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | 14,250,359.00 |
| Хөрөнгө худалдсаны гарз | | 14,250,359.00 |
| НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | | 334,906,380.96 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЙН
САНАА

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | | |
| 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 3,590,401,523.69 | | | 3,590,401,523.69 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 334,906,380.96 | 334,906,380.96 |
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,590,401,523.69 | | 334,906,380.96 | 3,925,307,904.65 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---------------------|-----------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | | 825,004,851.85 |
| ТАТААС САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | | 84,038,490.00 |
| Улсын төсвөөс | | 43,580,400.00 |
| Урсгал /тогтмол зардал/ | | |
| Тэтгэвэр, тэтгэмж | | |
| Тогтмол зардал | | 43,580,400.00 |
| Хөрөнгийн | | |
| Хөрөнгө оруулалт барилга | | |
| Хөрөнгө оруулалт СТТ, лаборатори | | |
| Бусад /замын зардал/ | | |
| Орон нутгийн төсвөөс /МСҮТ, Ахлах сургууль/ | | 19,642,090.00 |
| МСҮТ-ийн хувьсах зардал | | 19,642,090.00 |
| Лицей сургуулийн хувьсах зардал | | |
| Бусад төсөв байгууллагаас | | 15,816,000.00 |
| Тусламжийн орлого | | 5,000,000.00 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | | 740,966,361.85 |
| Өмчийн орлого | | |
| Төсөвт байгууллагын төлбөртэй үйлчилгээний орлого | | 464,119,990.00 |
| Бакалаврын сургалтын төлбөр | | 424,456,490.00 |
| Магистрын сургалтын төлбөр | | 28,549,500.00 |
| МСҮТ-ийн сургалтын төлбөр | | 11,114,000.00 |
| Бусад орлого | | 276,846,371.85 |
| Оюутны байрын орлого | | 220,327,300.00 |
| Үйл ажиллагааны бус орлого | | 56,519,071.85 |
| Гэрээт ажил, ЭШ-ний орлого | | 29,195,105.00 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | | 8,414,333.85 |
| Хураамж, бусад | | 18,909,633 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | | 388,072,283.91 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | |
| АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ | | 241,819,422.76 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | | 217,752,356.48 |
| Үндсэн цалин | | 217,752,356.48 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 24,067,066.28 |
| НДШ-ийн зардал | | 24,067,066.28 |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | | 143,361,750.15 |
| Нийтлэг чанартай зардал | | 97,765,460.75 |
| Бичиг хэргийн зардал | | 840,217.02 |
| Гэрэл цахилгааны зардал | | 14,921,462.15 |
| Түлш шатахууны зардал | | 11,276,840.00 |
| Цэвэр, бохир усны зардал | | 6,283,523.00 |
| Тээвэр шатахууны зардал | | 966,000.00 |
| Шуудан холбооны зардал | | 697,609.00 |
| Дотоод томилолтын зардал | | 1,171,430.00 |
| Аж ахуйн зардал | | 7,702,286.03 |
| Урсгал завсарын зардал | | 8,988,632.95 |
| Сургалт семинарын зардал | | 2,000,000.00 |
| Төлбөр, хураамж, банкны шимтгэл | | 321,219.60 |
| Харуул хамгаалалтын зардал | | 27,682,200.00 |
| Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардал | | 4,473,900.00 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИГ 3219.60
САНАЛ 27,682,200.00

| | | |
|--|--|------------------------|
| Бусад зардал | | 3,785,140.00 |
| Тусгай материал, үйлчилгээний зардал | | 45,596,289.40 |
| Хичээл сургалт, үйлдвэрийн дадлагын зардал | | 13,507,473.00 |
| Эрдэм шинжилгээний ажлын зардал | | 18,359,850.00 |
| Оюутны үйл ажиллагааны зардал | | 11,422,978.40 |
| Гадаад зочины зардал | | 2,305,988.00 |
| ТАТААС, САНХҮҮЖИЛТ | | 2,891,111.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | | 2,891,111.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | | 436,932,567.94 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | 13,114,710.00 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 13,114,710.00 |
| Дотоод эх үүсвэрээр | | |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | (13,114,710.00) |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | | 423,817,857.94 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 423,817,857.94 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.5 Аудит хийгдсэн орлого, зардлын гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|--|-------------------------|-------------------------|-----------------------|---------------|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| НИЙТ МӨНГӨН ДҮН | 1,076,712,901.83 | 1,081,154,351.85 | (4,441,450.02) | (0.41) |
| МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | - | - | - | - |
| Тайлант жилийн орлого | 1,076,712,901.83 | 1,081,154,351.85 | (4,441,450.02) | (0.41) |
| Үндсэн үйл ажиллагааны тайлан | 799,566,331.43 | 799,307,980.00 | 258,351.43 | 0.03 |
| Төсвийн санхүүжилт | 326,379,391.43 | 319,371,990.00 | 7,007,401.43 | 2.15 |
| Хөрөнгө оруулалт /барилга, ИЗ/ | 195,000,000.00 | 189,300,000.00 | 5,700,000.00 | 2.92 |
| Хөрөнгө оруулалт СТТ, лаборатори | 70,000,000.00 | 66,489,500.00 | 3,150,500.00 | 4.50 |
| МСҮТ-ийн хувьсах зардал | 17,929,600.00 | 19,642,090.00 | (1,712,490.00) | (9.55) |
| Тогтмол зардлын СХ | 43,449,791.43 | 43,580,400.00 | (130,608.57) | (0.30) |
| Сургалтын төлбөрийн орлого | 473,186,940.00 | 479,935,990.00 | (6,749,050.00) | (1.43) |
| Бакалаврын сургалтын төлбөр | 437,476,440.00 | 440,272,490.00 | (2,796,050.00) | (0.64) |
| Магистрын сургалтын төлбөр | 25,090,500.00 | 28,549,500.00 | (3,459,000.00) | (13.79) |
| МСҮТ-ийн сургалтын төлбөр | 10,620,000.00 | 11,114,000.00 | (494,000.00) | (4.65) |
| Туслах үйл ажиллагааний орлого | 277,146,570.40 | 281,846,371.85 | (4,699,801.45) | (1.70) |
| Оюутны дотуур байрны | 216,901,300.00 | 220,327,300.00 | (3,426,000.00) | (1.58) |
| Дотоод оюутны байрны орлого | 216,901,300.00 | 220,327,300.00 | (3,426,000.00) | (1.58) |
| Үйл ажиллагааны бус орлого | 60,245,270.40 | 61,519,071.85 | (1,273,801.45) | (2.11) |
| ЭШ-ний гэрээт ажил, төслөөс орох | 30,000,000.00 | 29,195,105.00 | 804,895.00 | 2.68 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 8,265,337.40 | 8,414,333.85 | (148,996.45) | (1.80) |
| Хандив | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | - |
| Хураамж, бусад | 16,979,933.00 | 18,909,633.00 | (1,929,700.00) | (11.36) |



| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|--|-----------------------|-----------------------|------------------------|----------------|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| НИЙТ ЗАРДАЛ | 697,468,727.56 | 657,336,493.91 | 40,132,233.65 | 5.75 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 417,468,727.56 | 388,072,283.91 | 29,396,443.65 | 7.04 |
| Цалин хөлсний зардал | 252,481,736.13 | 241,819,422.76 | 10,662,313.37 | 4.22 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 227,461,023.54 | 217,752,356.48 | 9,708,667.06 | 4.27 |
| НДШ | 25,020,712.59 | 24,067,066.28 | 953,646.31 | 3.81 |
| Бараа үйлчилгээний нийтлэг зардал | 45,715,000.00 | 41,143,533.60 | 4,571,466.4 | 10.0 |
| Бичиг хэрэг /захиргаа/ | 1,220,000.00 | 840,217.02 | 379,782.98 | 31.13 |
| Аж ахуйн зардал | 9,050,000.00 | 7,702,286.03 | 1,347,713.97 | 14.89 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 800,000.00 | 697,609.00 | 102,391.00 | 12.8 |
| Албан томилолт /захиргаа/ | 1,275,000.00 | 1,171,430.00 | 103,570.00 | 8.12 |
| Шагналын зардал | 900,000.00 | 850,000.00 | 50,000.00 | 5.56 |
| Төвлөрсөн арга хэмжээний зардал | 4,300,000.00 | 3,785,140.00 | 514,860.00 | 11.97 |
| ГАХ, хамтын ажиллагааны зардал | 3,000,000.00 | 2,305,988.00 | 694,012.00 | 23.13 |
| Тусламж тэтгэлэгийн зардал | 2,600,000.00 | 2,041,111.00 | 558,889.00 | 21.5 |
| Урсгал завсарын зардал | 9,280,000.00 | 8,988,632.95 | 291,367.05 | 3.17 |
| Төлбөр хураамжийн зардал | 7,600,000.00 | 7,321,219.60 | 278,780.40 | 3.67 |
| Хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны зардал | 4,560,000.00 | 4,473,900.00 | 86,100.00 | 1.89 |
| Сургалт үйлчилгээний зардал | 29,440,000.00 | 26,930,451.40 | 2,509,548.60 | 8.52 |
| Хичээл практикийн зардал | 14,440,000.00 | 13,507,473.00 | 932,527 | 6.46 |
| Оюутны үйл ажиллагааг дэмжих зардал | 12,000,000.00 | 11,423,000.00 | 577,000.00 | 4.81 |
| Уралдаан тэмцээний зардал | 500,000.00 | | 500,000.00 | 100 |
| Багш, ажилтны үйл ажиллагааг дэмжих зардал | 2,500,000.00 | 2,000,000.00 | 500,000.00 | 20.0 |
| Эрдэм шинжилгээ, инновацийн зардал | 19,000,000.00 | 18,359,850.00 | 640,150.00 | 3.37 |
| Эрдэм шинжилгээ, инновацийн зардал | 19,000,000.00 | 18,359,850.00 | 640,150.00 | 3.37 |
| Тогтмол зардал | 70,831,991.43 | 59,819,026.15 | 11,012,965.28 | 15.55 |
| Гэрэл цахилгаан | 17,602,611.63 | 14,921,463.15 | 2,681,148.48 | 15.23 |
| Халаалтын зардал | 18,732,649.00 | 11,276,840.00 | 7,455,809.00 | 39.8 |
| Цэвэр бохир усны төлбөр | 7,114,530.80 | 6,238,523.00 | 876,007.80 | 12.31 |
| Харуул хамгаалалтын зардал | 27,382,200.00 | 27,382,200.00 | - | - |
| Хөрөнгийн зардал | 280,000,000.00 | 269,264,210.00 | 10,735,790.00 | 3.83 |
| Тоног төхөөрөмж худалдан авах зардал | 6,300,000.00 | 5,964,460.00 | 335,540.00 | 5.33 |
| Тавилга эд хогшил худалдан авах зардал | 4,000,000.00 | 3,460,000.00 | 540,000.00 | 13.5 |
| Ном сурах бичиг худалдан авах зардал | 3,500,000.00 | 2,890,250.00 | 609,750.00 | 17.42 |
| Биет бус хөрөнгө | 1,200,000.00 | 800,000.00 | 400,000.00 | 33.33 |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт-барилга | 195,000,000.00 | 189,300,000.00 | 5,700,000.00 | 2.92 |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт-лаборатори | 70,000,000.00 | 66,849,500.00 | 3,150,500.00 | 4.5 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 379,244,174.27 | 423,817,857.94 | (44,573,683.67) | (11.75) |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ
3,150,500.00 - 4.5
(44,573,683.67) (11.75)

4.6 АУДИТ ХИЙГДСЭН УЛСЫН ТӨСВӨӨС АВСАН ХӨРӨНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|--------------------------|-----------------------|----------------------|----------------------|-------------|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 43,580,400.00 | 32,436,825.00 | 11,143,575.00 | 7,04 |
| Гэрэл цахилгаан | 17,602,611.00 | 14,921,462.00 | 2,681,149.00 | 15.24 |
| Халаалтын зардал | 18,732,649.00 | 11,276,840.00 | 7,455,809.00 | 39.8 |
| Цэвэр, бохир усны зардал | 7,245,140.00 | 6,238,523.00 | 1,006,617.00 | 13.9 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**